



АРДЧИЛСАН НАМ

**Монгол Улсын Их Хурлын  
2012 оны сонгуульд Ардчилсан  
намаас оролцох мөрийн  
хөтөлбөр**



ХАВСРАЛТ №1

**АРДЧИЛАЛ, ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ҮЗЭЛ САНААНД ТУЛГУУРЛАСАН  
НИЙГМИЙН ХӨГЖИЛД МОНГОЛЫН АРД ТҮМНИЙГ АНХЛАН УРИАЛАН  
ДУУДСАН УЛС ТӨРИЙН ХҮЧНҮҮДИЙН НЭГДЭЛ БОЛОХ АРДЧИЛСАН НАМ:**

- Үндэсний эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч, чинээлэг, эрх чөлөөт иргэдийн хариуцлагатай нийгмийг төлөвшүүлэх эрхэм зорилгоо нотлон,
- Хүний жам ёсны, заяагдмал эрх, хувийн өмч, төрийн хязгаарлагдмал оролцоо, төрийн нээлттэй, иргэдэд хянагдах тогтолцоо иргэний нээлттэй нийгэм, жөндөрийн тэгш байдал зэрэг Ардчилсан намын тулгуур үнэт зүйлсийг шалгуур болгон,
- Монгол төрийн бодлогын залгамж чанарыг эрхэмлэн,
- Сонгуулийн шинэ хуулиар тогтоосон хязгаарлалт хэм хэмжээг үндэслэн, “Монгол хүн 2020” хөтөлбөрийн хүрээнд Ардчилсан Намын гишүүд дэмжигчид, олон нийтийн нэмэрлэсэн санаа, санал санаачлагад тулгуурлан,
- Эдийн засгийн аюулгүй байдал, ардчилсан засгийн шударга тогтолцоог хангах, баялгийн шударга хуваарилалтанд түлхүү анхаарах цаг ирснийг тунхаглан

**УИХ-ЫН 2012 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРӨӨ СОНГОГЧ ТАНД  
ТОЛИЛУУЛЖ БАЙНА.**



## АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ХҮН

Хүн амын үндсэн хэрэгцээг тогтвортой хангахуйц, өөрийгөө тэтгэх чадвар бүхий олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эдийн засгийг бүрдүүлэхэд чиглэгдсэн төсөв, санхүү мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь макро эдийн засгийн хүрээний гол зорилт мөн.

- УИХ нь Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийн зарлагыг өсгөх, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх зарчмыг хуульчилна.
- Инфляцийг нэг оронтой тоонд барьж төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой байлгана.
- Цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.
- Цалин тэтгэврийн хэмжээг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг өсгөхгүйн тулд нийтэд зарлахгүйгээр салбар бүрээр нэмнэ.
- Улсын төсвийн зардлыг хязгаарлаж, дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн эзлэх хувийг 40-өөс илүүгүй байлгана.
- Мөнгөний бодлогыг бодит эдийн засгийг дэмжихэд чиглүүлнэ.
- Хөгжлийн банкнаас дэд бүтэц, боловсруулах үйлдвэрийг дэмжихэд олгох хөнгөлөлттэй зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Тендерийн будлиан, авлига, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100 хувь онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналтан дор ил тод явуулна.

- Төсөв, санхүү, боловсон хүчний томилгоотой холбоотой орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулна.
- Бусад улс орнуудтай хийсэн давхар татварын гэрээнүүдийг Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн шинэчлэх, эсхүл хүчингүй болгоно.
- Уул уурхай, ашигт малтмал, нефтийн бүтээгдэхүүний импорт, газрын тосны экспорт, үүрэн холбооны операторын үйлчилгээ, архи, спирт, тамхи зэргээс бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс илүүгүй аж ахуйн нэгжүүдэд төлсөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг өөрт нь буцааж олгоно.
- Төсвийн хөрөнгөөр худалдан авч буй бараа ажил үйлчилгээний нийлүүлэгч компаниудад нийт борлуулалтын гучин хувиас багагүй хэсгийг төсвийн бус хүрээнээс олдог байх шаардлага тавина.
- Гадаад улс орнуудын төрийн өмчит компаниудын хөрөнгө оруулалтыг хязгаарласан зохицуулалт хийнэ.
- Ажилгүйдлийг бууруулах үүднээс хөдөлмөрийн багтаамж ихтэй салбаруудыг бодлогоор дэмжинэ.
- Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан, цөөн улс орноос хамааралгүй болоход анхаарч өрсөлдөх чадварыг бэхжүүлнэ.
- Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэмжих замаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт татах боломжийг дээшлүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэрүүдэд олгож буй зээлийн олон эх үүсвэрүүдийг нэгтгэн зангидаж, үйл ажиллагааг нь үр дүнтэй болгоно.

Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дараахь бодлогыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Уул уурхайн салбар дахь төрийн зохицуулалт, хяналтыг чангатгаж, төрийн өмчийн оролцоог хязгаарлаж, үндэсний аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог дэмжинэ.
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч гэрээ байгуулдаг зарчмыг хэрэгжүүлнэ.
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын газраас олгодгийг зогсоож Засгийн газар олгодог болгоно.
- Хуулийн этгээдийн эзэмшиж болох ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоонд тодорхой хязгаарлалт тавина.
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн төрөөс тогтоосон нутаг дэвсгэрт олгодог болно.
- Эрдэс баялгийн экспортийг “Нэг цонх”-ны бодлогоор хэрэгжүүлнэ.
- Уул уурхайн ордуудыг түшиглэн байгуулагдах компаниудад Монголын талын оролцоог 51 хувиас багагүй байлгах эрх зүйн орчныг бий болгож, хэрэгжүүлнэ.
- Эдийн засгийн үр ашиг муутай, байгаль орчинд хор хөнөөл ихтэй уурхайг ажиллуулахыг хориглоно.
- Байгаль орчинд ээлтэй, шилдэг техник, технологийг уул уурхайн үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, эвдрэлд орсон талбайг тоолж дуусган, буруутай этгээдээр нөхөн сэргээлгэж, цаашид нөхөн сэргээлтийн зардлыг улсын төсвийн дансанд байршуулдаг болгоно.

- Уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг татварын бодлогоор хөхиүлэн дэмжинэ.
- Монголд хэрэгжиж буй уул уурхайн болон бусад том төслүүдэд, үндэсний аж ахуй нэгж, тэдний хөрөнгө оруулалттай ААН бараа ажил үйлчилгээ нийлүүлэх туслан гүйцэтгэгчээр ажилллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордууд дээр байгуулагдах компанийн 51-ээс доошгүй хувийг төр эзэмшдэг байна.
- Эрчим хүчний болон коксжих нүүрс, зэс, төмрийн хүдэр болон газрын ховор элемент зэргийг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ангилалд оруулж, тусгайлсан бодлогыг хэрэгжүүлнэ.
- Уул уурхайн салбарын түүхий эдэд нэмүү өртөг шингээх бодлого хэрэгжүүлэн хагас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортлоно.

Уул уурхайн салбарын хамаарлыг бууруулах, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадвар бүхий олон тулгуурт эдийн засгийг бий болгох нь эдийн засгийн бодлогын тэргүүлэх зорилт байна. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Эдийн засгаа солонгоруулах бодлогыг дараахь долоон чиглэлээр явуулна.

Нэг. Үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр:

- Уул уурхайн бүтээгдэхүүнийг боловсруулах зорилгоор аж үйлдвэрийн анхны паркийг Дорноговь аймгийн Сайншанд хотод байгуулна. Үүнд:
  - Жилд нэг сая тонн кокс боловсруулах үйлдвэр,
  - Жилд 850 мянган тонн бензин, 85 мянган тонн шингэн байгалийн хий үйлдвэрлэх хүчин чадалтай нүүрс шингэрүүлэх үйлдвэр,

- Жилд 660 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай зэс боловсруулах үйлдвэр,
  - Жилд 500 мянган тонн эцсийн бүтээгдэхүүн гаргах хүчин чадалтай төмөрлөгийн үйлдвэрийг тус тус байгуулна.
  - Сайншандын бүтээн байгуулалтад шаардагдах дэд бүтэц, 600-800 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц, төмөр замын өртөө, автозамыг байгуулна.
  - Сайншандад төмөр зам, авто зам, нисэх онгоцны буудал бүхий тээврийн зангилаа байгуулна.
- Дархан хотын төмөрлөгийн үйлдвэрийг шинэчилж, хүдэр баяжуулдаг болно.
  - “Замын Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг цогцоор нь барьж дуусгана. “Чойр” ложистикийн төвийн эхний ээлжийн дэд бүтцийг барьж, байгуулна.
  - Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, цемент, төмөр хийц, шил, дулаалгын материал зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтлана.
  - Эрчим хүчний нүүрсний уурхайнуудыг түшиглэн аймгуудад дулааны болон эрчим хүчний цахилгаан станц байгуулна.
  - Нар, салхи, нүүрсээр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн, Азийн нэгдсэн сүлжээнд холбогдоно.
  - Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудыг төрөөс татварын бодлогоор дэмжинэ.
  - Сэлэнгэ мөрөн дээр Усан цахилгаан станц байгуулна.

- Улаанбаатар хотын хэрэгцээг хангах зорилгоор 5-р цахилгаан станцын эхний ээлжийг ашиглалтад оруулна.
- Алтай-Улиастайн системийг байнгын найдвартай эрчим хүчний эх үүсвэрээр хангах зорилгоор Могой голын нүүрсний ордыг түшиглэн 60МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулна.

Хоёр. Ноос, ноолуур, арьс ширний чиглэлээр явуулах бодлого:

- Ноолуурын салбарын зээлийн санг 300 тэрбум, арьс ширний салбарын зээлийн санг 300 тэрбум, ноосны салбарын зээлийн санг 50 тэрбум, махны үйлвэрлэлийг дэмжих зээлийн санг 100 тэрбум төгрөгт хүргэнэ.
- Малын гаралтай түүхий эд ноолуур, ноос, арьс ширийг эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж зах зээлд нийлүүлдэг болгоно.
- Ноос, ноолуур, арьс ширний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжихэд чиглэгдсэн оёмол бүтээгдэхүүн-дизайны парк байгуулна.
- Улаанбаатар хотод ноолуурын үйлдвэр технологийн парк байгуулна.
- Дархан хот, Улаанбаатар хотын орчимд байгаль орчинд ээлтэй, хаягдлаа бүрэн боловсруулах чадвартай арьс шир боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

Гурав. Уламжлалт мал аж ахуй, мах сүүний чиглэлээр явуулах бодлого:

- Малын индексжүүлсэн даатгалыг давхар даатгалд хамруулах замаар олон улсын стандартын дагуу мал сүргийг бүрэн бүртгэж даатгана.



- Малын гоц халдвар, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, үйлчилгээний төсвийг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- Хөдөө аж ахуйн их сургуульд түшиглэн малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулахад чиглэгдсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлдэг тогтолцоог бий болгоно.
- Хангайн аймгуудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны аж ахуйг дэмжинэ. Дархан, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Хэнтий, Дорнод, Архангай аймгийн газар тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.
- Сум болгонд малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх, зах зээлд нийлүүлэх тогтолцоог хөдөө аж ахуйн бараа, түүхий эдийн биржийн салбар хэлбэрээр бий болгоно.
- Сумын хөгжлийн сангийн эх үүсвэрийг 300 саяаас доошгүй, аймгийн ЖДҮ-ийг дэмжих дэд санг 5 тэрбумаас доошгүй, Бүс нутгийн хөгжлийн дэмжих, ЖДҮ-ийн сангийн эх үүсвэрийг 500 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй болгоно.
- Малчдаас үндэсний үйлдвэрлэлд нийлүүлэх бүтээгдэхүүний зохион байгуулалт, эдийн засаг санхүүгийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.
- Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувууны аж ахуй эрхэлж буй аж ахуйг дэмжих зээлийн санг 50 тэрбумаас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй байгуулна.
- Цөлжилт, бэлчээр талхлалтыг бууруулах зорилгоор бэлчээрийн менөжментийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж аймаг сум дамнасан бэлчээрийн бүсийг бий болгох эрхзүйн орчныг бүрдүүлнэ.

- Дархан, Сэлэнгийн газар тариалангийн бүс нутаг дахь эрчимжсэн мал аж ахуйн фермөрийг түшиглэн мах, сүүний үйлдвэрлэлийн цогцолбор байгуулна.
- Аймаг бүрт шинээр олон улсын стандарт хангасан махны үйлдвэр барьж, жилд бог малын махны экспортыг 30 мянган тонноос доошгүй хэмжээнд хүргэнэ.
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод олон улсын стандартад нийцсэн мах нөөцлөх зориулалт бүхий агуулах, бөөний худалдааны төвүүдийг барьж байгуулна.
- Газар тариалан, фермерийн бүс нутгуудыг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгийн төв бүрт цэцгийн тос, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахыг зээлээр дэмжинэ.
- Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлнэ.

Дөрөв. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлого:

- Гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгоно.
- Монгол Улс руу чиглэсэн олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг хоёр дахин нэмэгдүүлнэ.
- Говийн аялал жуулчлалын бүс, Орхоны хөндийн аялал жуулчлалын бүс, Хөвсгөл нуурын аялал жуулчлалын бүсийг холбосон дэд бүтэц байгуулна.
- Орхоны хөндийн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлж Хархоринг байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын хот болгон хөгжүүлнэ.

- Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын хөтөлбөр хөгжүүлнэ.
- Монгол ахуй, соёлыг гадаад улсад сурталчлах цогц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Үлэг гүрвэлийн музей, парк, палентологийн лабораторийг улсын төсвөөр байгуулна.
- Бүх аймгуудад орон нутгийн уран зураг, гар урлал, фото зургийн галерей байгуулахыг дэмжинэ.

Тав. Өндөр технологи, био, нано, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого:

- Их дээд сургуулиудыг түшиглэн өндөр технологийг дэмжих сургалтын тогтолцоог бий болгох замаар өндөр технологийн салбарт суралцан төгсөгчдийн тоог жилд нэг мянгад хүргэнэ.
- Өндөр технологийн салбарт бусад орнуудтай багш солилцох ажлыг зохион байгуулж, жилд 30-аас доошгүй өндөр мэргэшилтэй багш нарыг Монгол Улсад багшлуулж, 50-иас доошгүй багш нарыг гадаадын нэр хүнд бүхий их сургуулиудад дадлага хийлгэнэ.
- Мэдээлэл холбоо, нано, биотехнологийн чиглэлээр гадаад дотоодын их дээд сургуулиудын хамтын ажиллагааг хөгжүүлж, дээрх мэргэжлүүдээр жилд 300-аас доошгүй оюутныг оюутан солилцоогоор дэлхийн шилдэг сургуулиудад сургана.
- Их сургуулиудын бие даасан байдлыг бэхжүүлэх, сургалт-судалгааны бие даасан төв болгож хөгжүүлэх зорилгоор шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэн их дээд сургуулиудын дунд нээлттэй өрсөлдөөнт шалгаруулалтаар судалгааны ажлыг санхүүжүүлдэг болно.

- Мэдээлэл холбооны технологийн салбарт инновацийн бодлого хэрэгжүүлэн сургалт-судалгаа-үйлдвэрлэл хосолсон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий технологийн паркийг Багануур дүүрэгт байгуулна.
- Нано, биотехнологийн салбарт лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэхэд хөрөнгө оруулалт хийж, лабораторийн хүчин чадлыг гурав дахин нэмэгдүүлнэ.
- Төлбөр тооцоо, бүртгэлийн бүх үйл ажиллагааг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хийж гүйцэтгэдэг орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
- Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой биотехнологийн төслүүдийг санхүүжүүлдэг механизмыг нэн түрүүнд бий болгоно.

Зургаа. Импортыг орлох, улмаар экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого:

- Төмс, хүнсний ногоо, сүү, өндөг болон импортоор оруулж ирдэг хүнсний бусад бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болно.
- Тариалан эрхлэлтийн дэмжих сангийн үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцоотой корпораци болгон зохион байгуулна.
- Баруун бүсэд газар тариалан эрхлэлтийг хөгжүүлж, бүсийн гурилын хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангадаг болно.
- Хүнсний ногооны тариалалт, хураалтыг механикжуулж, агуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар дотоодын хэрэгцээг бүрэн хангана.
- Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
- Аймгуудад усалгаатай газар тариаланг дэмжинэ.

- Боловсруулах үйлдвэр байгуулан Монгол Улсад олборлож байгаа ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрт эхний ээлжинд нийлүүлдэг болгоно.
- Уул уурхайн үйлдвэрүүд хэрэгцээтэй бараа, үйлчилгээг тэргүүн ээлжинд дотоодоос худалдан авахыг үүрэгжүүлсэн хууль гаргана.
- Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор газрын тосны олборлолтыг нэмэгдүүлж, Дорнод, Зүүнбаян зэрэг газруудад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.
- Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг бий болгох зорилгоор улсын нөөцийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Шатахууны бөөний худалдаанд татварын хөнгөлөлт эдлүүлдэг тогтолцоог өөрчилж, жижиглэнгийн үнийг тогтвортой байлгана.
- Нүүрснээс хий, шингэн түлш гаргах судалгааны ажлыг эрчимжүүлж дэвшилтэт технологи нэвтрүүлэн хийн түлш, нефть бүтээгдэхүүний гадаад хамаарлаас ангижирч дотоодын эх үүсвэртэй болно.
- Хийн түлшний тээвэрлэлт хадгалалт, хамгаалалт, түүнд тавигдах стандартыг сайжруулах замаар хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлнэ.
- Метан хий, шатдаг занар болон бусад эх үүсвэрийн талаарх судалгааг эрчимжүүлж, ашиглалт олборлолтын асуудлаар бодлого боловсруулан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Долоо. Үйлчилгээний бизнесийг дэмжих чиглэлээр

- Найдвартай, аюулгүй, мэдлэг, ур чадварт суурилсан үйлчилгээний салбартай улс орон болно.
- Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг онцгойлон дэмжинэ.

- Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодод тус салбарын хэмжээнд мөрдөх стандарт, ёс зүйн дүрэм, үйлчилгээний зэрэглэл, тарифын зохицуулалтыг батлах эрх олгоно.
- Такси, зочид буудал, зоогийн газар болон бусад үйлчилгээний ажилтанд англи хэл сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн хөгжлийг хангах, тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор дэд бүтэц, хот байгуулалт, аймаг сумыг хөгжүүлэх талаар дараахь бодлогыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилж, аж үйлдвэрийн болон экологийн тэргүүлэх хөгжлийн бүсүүдийг тогтооно.
- Бүсийн дагуух үндсэн дэд бүтцийг байгуулж, эдийн засгийн болон ажиллах хүчний хязгаарлагдмал нөөцийг тулгуур хотуудад байршуулах замаар хөгжих бодлогыг тодорхойлно.
- УИХ-аас баталсан “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөр, Төмөр замын талаар баримтлах төрийн бодлогод тусгагдсан төмөр замыг хөтөлбөр, бодлогод тусгасан үе шатын дагуу барьж байгуулна.
  - Даланзадгад-Таван Толгой-Цагаан Суварга-Зүүнбаян, 400 км
  - Сайншанд-Баруун Урт, 350 км
  - Баруун Урт-Хөөт, 140 км
  - Хөөт-Чойбалсан, 150 км
  - Замын үүд, Алтанбулагийн боомтын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.
  - Нарийнсухайт-Шивээхүрэн-45.5 км
  - Ухаа худаг-Гашуунсухайт-267 км
  - Хөөт-Тамсагбулаг-Нөмрөг-380 км
  - Хөөт-Бичигт-200 км
- Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой болон ойролцоох хилийн боомттой хатуу хучилттай нийт 5572 км авто замаар холбоно.

- Улаанбаатар хотын авто замын сүлжээг тойрог замын системд шилжүүлж, гүүрэн гарц, хоёр түвшний уулзваруудыг шаардлагатай газруудад барьж байгуулна.
- Транзит тээврийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хурдны зам барьж ашиглалтад оруулна.
- Олон улсын автозамын сүлжээний АН-3 ЗамынҮүд-Улаанбаатар-Алтанбулагийн автозамыг ашиглалтад оруулна.
- АН-4 Улаанбайшинт-Өлгий-Ховд-Ярант, Ховд-Улаангом чиглэлийн авто замыг ашиглалтад оруулна.
- Далайд гарцгүй орны хувьд агаарын харилцааг эдийн засгийн тэргүүлэх чиглэлд тооцон төрийн бодлогоор дэмжин хөгжүүлнэ.
- Хөшигтийн хөндийд шинээр баригдах олон улсын нисэх онгоцны буудлыг олон улсын зорчигч болон ачаа тээврийн өрсөлдөх чадвар бүхий төв болгоно.
- Агаарын тээврийн салбарыг чөлөөлөх бодлогыг 2016 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.
- МИАТ ХК-ийг үндэсний агаарын тээвэрлэгчийн статус олгож, 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгана.
- “Шинэ Улаанбаатар” төслийн хүрээнд хот төлөвлөлтийг шинээр хийж, нэгдсэн бодлогоор инженерийн дэд бүтцийг байгуулан, Улаанбаатар хотод 17 иж бүрэн хорооллыг барьж байгуулна.
- Дархан хотыг дэлхийн жишигт нийцсэн Монгол Улсын анхны жишиг хот болгон хөгжүүлнэ.

- Сум бүрт 50 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэр бүхий “Бэлчээр хамгаалах сан”-гийн эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого:

- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамыг өөрчлөн зохион байгуулж хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалт, жижиг дунд үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн Хөдөлмөрийн яам байгуулна.
- Залуучууд болон 40-өөс дээш насны ажил олоход хүндрэлтэй байгаа иргэнийг ажлын байраар хангах хүрээнд:
  - Ажилд авсан аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлнэ.
  - Ажил хайж байгаа иргэнийг дахин сургалтад хамруулна.
  - Нөхөрлөл, хоршоо байгуулахыг бүх талаар дэмжинэ.
  - Хот суурингаас хөдөө орон нутагт шилжин суурьшиж ажиллагсдыг дэмжих зэрэг ажлыг зохион байгуулна.
- Ажлын байр бий болгох зорилгоор үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын тусгай сангуудыг нэгтгэнэ.
- Бүх сум, дүүрэгт ажил хайгч болон ажил олгогчтой шууд уулзуулах хөдөлмөр зуучлалын мэдээллийн онлайн сүлжээг нэвтрүүлнэ.
- Эх /эцэг/ нь төрүүлсэн хүүхдээ 2 нас хүртэл, ихэр хүүхдийг 3 нас хүртэл өөрөө асран хүмүүжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бий болгож хэрэгжүүлнэ.

Нийгмийн хамгааллын бодлого:

- Олон давхаргат тэтгэвэрийн тогтолцоог нэвтрүүлж уул, уурхайн баялагийн орлогоос баялагийн сан байгуулж, сангийн 60 хүртэлх хувийг ирээдүйн тэтгэвэрийн сангийн нөөц болгоно



- 1990-1995 оны хооронд өөрөөс үл хамаарах шалтгааны улмаас ажил хөдөлмөр эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй байсан иргэдийн ажилласан жил тасарсаныг ажилласанаар нөхөн тооцох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон буюу 1995 оноос өмнөх ажилласан жил, авсан цалингаасаа тооцож тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрийн зөрүүг арилгана.
- Зорилтот бүлгүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлого хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төвийг аймаг, дүүрэг бүрт бий болгоно.
- Ахмадуудыг нийгмийн тустай ажил эрхлэх, хамтарч ажиллах санаачлагыг дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн хэмжээг нэмэгдүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүргэнэ.
- Цөөн мал бүхий малчин өрхийн амьдралыг баталгаажуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ
- Өндөр настны асрамжийн төвийг хувийн хэвшлийн байгууллага шинээр байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 16 нас хүртэлх өнчин, хагас өнчин хүүхдийн эдийн засгийн баталгааг төрөөс хариуцна.
- Хараагүй иргэдэд зориулсан явган хүний зам, замын хөдөлгөөнд оролцоход дуутай гэрлэн дохиоллыг нэвтрүүлэх асуудлыг хот төлөвлөлтийн бодлогод тусгана.

- Шинээр баригдаж буй орон сууц, сургууль, үйлчилгээний газарт тэргэнцэртэй иргэдэд зориулсан шат, зам тавих асуудлыг барилгын стандартад нэвтрүүлнэ.



## ЭРҮҮЛ ЧИЙРЭГ МОНГОЛ ХҮН

Шударга өрсөлдөөн сонголтонд суурилсан хамгийн чанартай эрүүл мэндийн оношлогоо эмчилгээ үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох нь эрүүл мэндийн салбарын үндсэн зорилт мөн.

- Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж, түргэн тусламжийн сүлжээний хөрөнгө оруулалтын хэмжээг 2013 онд 5 дахин нэмэгдүүлж, бүх шатны эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.
- Эрүүл мэндийн даатгалын санг бие даалган, даатгалын санхүүжилтийг нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлнэ.
- Оношлогоо, эмчилгээний чанарын хяналтын үнэлгээг үндэслэн улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг тарифийн ялгаваргүйгээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.
- Өрхийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бүрдүүлж, эрүүл мэндийнхээ төлөө хүлээх гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг төрийн албаны бүтцээс гаргаж нэгдсэн эмнэлэг, үндэсний төвүүдийн санхүүгийн бие даасан үйл ажиллагааг хангаж, эмч сувилагчдын ажлын ачаалал, ур чадварт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.
- Төсвийн санхүүжилтыг эрүүл мэндийн даатгалын сантай уялдуулж, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээр үйлчлэх үйлчилгээг эрүүл мэндийн, даатгалд хамруулж, өрхийн эрүүл мэндийн төв, гэрээнд заагдаагүй бусад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Иргэдийг цахим карт, хувийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн сантай болгож, эрүүл мэндийн даатгалтай иргэн харьяалал харгалзахгүйгээр

аль ч эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авах боломжтой болгоно.

- Телемедицины үндэсний сүлжээг байгуулж, зайн оношлогоог өргөтгөнө.
- Эмнэлгийн яаралтай тусламжийн нэгдсэн сүлжээг бий болгож, алсын дуудлагад бүх төрлийн тээврийн хэрэгсэл ашиглах нөхцлийг бүрдүүлж, явуулын болон сэхээн амьдруулах тасгуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- Нэг өвчтөнд ногдох сувилалчийн тоог олон улсын жишигт хүргэж өвчтөнд үйлчлэх асаргаа сувилгааны чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- Анагаахын боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх, нарийн мэргэшлийн эмчийг дотоод, гадаадад бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- Оношлогоо эмчилгээний үндэсний төвийг ашиглалтад оруулж, оношлогоо эмчилгээнд анагаахын шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлж, иргэн хүн эх орондоо эмчлэгдэх нөхцлийг бүрдүүлнэ.
- Хүүхдэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгож, утаа хөрс усны бохирдолтоос болж эрүүл мэндээр хохирсон иргэний оношлогоо, эмчилгээний зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.
- Аймаг, нийслэл, дүүрэгт усан бассейн бүхий спортын ордон барих ажлыг үргэлжлүүлж, дугуйн болон гүйлтийн зам, мөсөн гулгуурын талбай шинээр барьж хүн бүр биөийн тамир, спортоор хичээллэх, хот, суурин газар, байгууллага хамт олон, өрх гэр бүлд эрүүл амьдралын орчин нөхцлийг бүрдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололттой уялдуулан эмчилгээ, сувилгааны чанар, үр өгөөжийг дээшлүүлж, рашаан сувилалын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.
- Бүртгэл мэдээллийн цахим санд тулгуурласан хяналтын биө даасан тогтолцоог бүрдүүлж, эм, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангана.
- Орчин үеийн эмийн Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн хамт, уламжлалт шинэ эм, тангийн үйлдвэрлэлийг өргөтгөж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэд 3 жилд нэг удаа эрүүл мэндийн иж бүрэн оношлогоонд хамруулна.

- Боловсролын байгууллагын менежментийн мэдээллийн системийг байгуулж, түүн дээр тулгуурлан багшлах боловсон хүчин мэргэжлээрээ нэгдэж, харилцан мэдээлэл туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлдэг мэдээллийн цахим сүлжээг байгуулна.
- Ур чадвар, бүтээмж, гүйцэтгэл дээр суурилсан цалин, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх замаар багшийн ажлыг шударгаар үнэлж, мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг өсгөж, цалингаараа хангалуун амьдрах, орон сууц худалдан авах боломжийг бүрдүүлсэн “Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Алслагдсан аймаг сумдад багшилж байгаа багш нарын цалин урамшуулал, орон сууцны нөхцлийг сайжруулахад чиглэсэн тусгай бодлого хэрэгжүүлнэ.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, элсэгчдийг ажил олгогчийн гэрээ, захиалга дээр тулгуурлан элсүүлж, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцлийг бүрдүүлнэ.
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа сурагчдын сургалтын тэтгэлгийг бууруулалгүйгээр суралцах сонирхлыг дэмжиж ажиллана.
- Чанаргүй их, дээд сургуулиудыг цөөлж сургалт, судалгаа, үйлдвэрлэл хосолсон, зах зээлд эрэлт хэрэгцээтэй боловсон хүчин бэлтгэдэг сургалтын системд шилжүүлж, дэргэдээ эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, туршилтын инкубатор байгуулж, түүндээ өндөр технологийн компанийг бойжуулж, зах зээлд нэвтрүүлэхийг төрөөс дэмжинэ.
- Инженер, технологийн чиглэлийн дэлхийн шилдэг 50 их сургуулийн нэгээс доошгүй салбарыг байгуулахыг дэмжинэ.

- Их сургуулиудын хотхон байгуулах ажлыг түргэвчлэх, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын асуудлуудыг шийдвэрлэнэ.
- Багш, эмч, инженер бэлтгэх асуудал дээр онцгой анхаарал хандуулж, амжилттай суралцаж байгаа оюутныг дэмжинэ.
- Шинжлэх ухааны бүтээлийг дэмжих, чанарыг сайжруулах, зах зээлд нэвтрүүлэхийн тулд шинжлэх ухаан, технологийн сангаас жил бүр хуваарилдаг төсвийг их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын дунд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах замаар хуваарилдаг болно.
- Үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг дээшлүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах замаар Монгол үндэсний соёлыг дэлхийн соёлын ололттой нийцүүлэн хөгжүүлнэ.
- Монгол үндэстэн, угсаатан, үндэсний цөөнхийн өв соёл, түүх, ёс заншлыг тэгш хүндэтгэн, өвлүүлэн хөгжүүлнэ.
- Соёл урлагийн салбарт өмчийн олон хэлбэр, зах зээлийн шударга, чөлөөт өрсөлдөөнийг бий болгож, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлж, соёлын үйл ажиллагаанд гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангана.
- Соёлын үнэт зүйлсийг бүтээн туурвигч, соёлын үнэт биет бус өвийг өвлөн уламжлагчийг төрийн анхаарал халамжид байлгана.
- Соёлын байгууллагын барилга байгууламжийн стандартыг бий болгож шаардлагатай музей, театрын барилгыг шинэчлэнэ.
- Түүх, палентологи, архелогийн олдворыг нэгдсэн бүртгэлд оруулж, хадгалж хамгаалах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авъяас, хөдөлмөр бүтээлийг дэмжинэ.
- “Монгол хүн” бэлтгэдэг бага ангийн тогтолцоог бүрдүүлж хүүхдийг эх хэл, бичиг үсэг, түүхээ бүрэн төгс эзэмших, үндэсний соёлын мэдрэмж, мэдлэг, хүмүүжилтэй болгох ажлыг хийнэ.
- Дэлхийн Монгол соёл судлалын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь төрөөс тусгайлан дэмжинэ.





## АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН

### Байгаль орчин

- Орон нутгийн иргэний байгууллага, иргэдийн нөхөрлөлтэй байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог шинэ шатанд гаргана.
- Амьсгалах агаартай, уух устай, аюулгүй амьдрах хоттой болох нөхцлийг бүрдүүлнэ.
- Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд сөрөг нөлөө үзүүлэх цацраг идэвхит болон химийн хорт бодисын хэрэглээг багасгаж, онцгой хорт бодис худалдах, ашиглах, тээвэрлэх, хадгалах, импортлоход тавих хяналтыг хүчтэй болгоно.
- Томоохон гол мөрнүүдэд урсацын тохиргоо хийх замаар усны сан байгуулж бүс нутгийн усны хэрэгцээг хангана. Хөв цөөрмүүдийг аймаг бүрт байгуулна.
- Гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад хамруулж, гол усыг эзэнтэй болгоно.
- Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.
- Ойг түймэр, хөнөөлт шавьж, өвчин, хууль бус мод бэлтгэлээс хамгаалах ажлыг эрчимжүүлж, ойг зүй зохистой ашиглах, мод орлох технологийг нэвтрүүлнэ.
- Устах аюулд орж байгаа амьтан, ургамлаа хамгаалах, уугуул нутагт нь сэргээх, тарималжуулах ажлыг эрчимжүүлнэ.

- Дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, нөхөн сэргээлтийн хөрөнгийн баталгаа гаргадаг тогтолцоог бий болгоно.
- Уул уурхайн нөхөн сэргээлтэд “дүйцүүлэн хамгаалах” мөханизмыг нэвтрүүлнэ.
- Байгаль орчинд хохирол учруулсан талаар бодитой мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.

#### Батлан хамгаалах бодлого

- Батлан хамгаалах нь бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан Төрийн батлан хамгаалах бодлогыг шинэчлэнэ.
- Батлан хамгаалах төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.
- Зэвсэгт хүчний нэгдмэл байдлыг хангаж, мэргэжлийн цэрэгт суурилсан орчин үеийн Зэвсэгт хүчинтэй болно.
- Хил хамгаалах бодлогыг шинээр тодорхойлж, улсын хилийн хамгаалалтад орчин үеийн зэвсэглэл, техникийг нэвтрүүлнэ.
- Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхийг бэхжүүлж, үндэсний байнгын хүчний тогтолцоог бүрдүүлнэ.
- Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлнэ. Зэвсэгт хүчинд эх оронч үзэл, хүмүүжил, хүний хөгжил, төлөвшлийн орчинг бүрдүүлнэ.

- Цэргийн алба хаагчдын эрх зүй, нийгмийн баталгааг сайжруулна. Зэвсэгт хүчний нийт офицер, ахлагчийн албан тушаалын орон сууцны хангамжийг бүрэн шийдвэрлэнэ.

#### Гадаад харилцаа

- Төрийн гадаад бодлого нэгдмэл байх, Засгийн газрын байгууллагуудын гадаад бодлого, гадаад харилцаа харилцан зохицуулалттай байх зарчмыг хэрэгжүүлнэ.
- Монгол иргэд ихээр зорчдог ОХУ, БНСУ, Япон, АНУ, Европын холбооны орнуудад зорчих визний нөхцлийг хөнгөвчилнө.
- Хил орчмын худалдааг дэмжиж, орон нутгийн иргэдийн түр хугацаагаар хил нэвтрэх боломжийг сайжруулна.
- Дипломат ажилтны эрх зүйн байдлын тухай хуулийг шинээр боловсруулж, гадаад харилцааны алба бүхэлдээ мэргэшсэн дипломатчдаас бүрддэг байх тогтолцоог бэхжүүлнэ.
- Гадаадад зорчихдоо осолд орох, өвдөх, нас барах, халдлагад өртөх, гэмт хэрэгт холбогдох үед Монгол Улсын иргэнд нэн яаралтай зохих тусламжийг үзүүлдэг болгоно.
- Гадаадад байгаа монгол иргэдийн байгуулсан сайн дурын холбоо, нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжиж, “Монгол Монголдоо тусална” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй монгол иргэдийн ажиллах нөхцөл, ажлын цаг, цалин олголтод Засгийн газрын зүгээс хяналт тавьж, иргэнийхээ эрх ашгийг хамгаална.
- Гадаадад ажиллагсдын тэтгэвэр тогтоолгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

- Гадаадын харьяат болсон Монгол Улсын уугуул иргэний эх нутагтаа зорчих, эх хэл соёлоо сурах, эх нутагтаа ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
- Гадаад улсад амьдарч байгаа иргэдийн хүүхдүүдэд монгол хэл, соёлыг сургах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.
- Гадаадад байгаа иргэдэд үзүүлэх консулын үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгоно.

#### Нийгмийн аюулгүй байдал

- Ган зудаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бий болгож, бэлэн байдлын нөөцийн хэмжээг шинэчлэн тогтооно. Газар хөдлөлт болон бусад гамшгийн мэдээлэл, судалгааны газрын хүчин чадал, төхник технологийг шинэчлэнэ.
- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хаягдал булшлахыг хатуу хориглоно.
- Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулахыг дэмжинэ.
- Малын хулгайтай тэмцэх асуудлын хүрээнд байнгын ажиллагаатай цахим сүлжээ, лавлах утас ажиллуулж үнэн зөв мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулдаг тогтолцоог бүрдүүлнэ.
- Хар тамхи, хүний наймааны гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар тусгай боловсон хүчин бэлтгэх, гадаад орны туршлага судлах, хүчний байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах.
- “Архигүй Монгол хүн” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
  - Спиртийн үйлдвэрлэлд улсын монополь тогтооно.

- Архиар шахдаг, архидалт зохион байгуулдаг явдлыг таслан зогсоож, архидалтын эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжиж ажиллана.
- Төсвийн мөнгөөр архи, согтууруулах ундаа худалдаж авахыг хуулиар хориглоно.
- Архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй, эрүүл идэвхитэй амьдралын клубийг аймаг, дүүрэг, сум бүрт байгуулахыг дэмжинэ.
- Согтууруулах ундааны хатуулаг болон савлах хэмжээг бууруулах бодлого баримталана.
- Өндөр хатуулагтай согтууруулах ундааны татварыг эрс нэмэгдүүлнэ.



## ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН

- Дотоод хэргийн яамны чиг үүргийн давамгайлсан байдлыг халах замаар Хууль зүйн яамны чиг үүрэг, зохион байгуулалтыг сайжруулж, хууль зүйн бодлогыг хүний эрх, эрх зүйт ёсны шинэтгэлд чиглүүлнэ.
- Төрийн албан тушаалтны эрх мэдлийг тодорхойлсон хууль зүйн бодлогыг өөрчилж, иргэний эрхийг хамгаалж, иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэнэ.
- Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийг үнэлдэг болно.
- Төрийн бүх шатны албан хаагчдын үүрэгжүүлж, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болно.
- Даргын шийдвэрийг биш хуулийг хэрэгжүүлдэг болно.
- Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.
- Хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хуульчдын ажил, мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгуурын гол үзүүлэлт болгоно.
- Ардчилсан нийгмийн зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн орчин үеийн эрүүгийн хуультай болно.
- Иргэний үндсэн эрхийн хяналтыг Үндсэн хуулийн цэцэд олгож иргэний үндсэн эрхийн баталгааг сайжруулна.
- Хууль зүйн мэргэжлийн болон иргэний боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, хууль зүйн боловсролыг шинэ шатанд гаргана.
- Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг чадавхижуулна.

- Төрийн албыг нийтийн алба болгон шинэчлэн зохион байгуулж, иргэдэд өдөр тутам үйлчилдэг "иргэний алба" бий болгож цахимжуулна.
- Авлига, ашиг сонирхолын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, төрийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй, хүнд сурталгүй болгоно.
- УИХ-д Өргөдлийн байнгын хороог байгуулж, шууд ардчиллын элементийг парламентын хяналтад оруулна.
- УИХ-ын нээлттэй сонсголын хэлбэрүүдийг хуульчлан баталгаажуулна.
- УИХ-ын хяналтыг сайжруулж, аудит, хүний эрх, статистик, авлигын хяналт зэрэг парламентын хяналтын бие даасан байгууллагуудыг иргэдийн хяналттай уялдуулан шинэчилнэ.
- Төрийн албаны зөвлөлийг татан буулгаж, Засгийн газрын байгууллага болгон өөрчлөн зохион байгуулна.
- Удирдлагын академийг төрийн албан хаагчдын үргэлжилсэн сургалтын институт болгон өөрчилнө.
- Залуучуудын хөгжлийн асуудлыг үндэсний хэмжээнд бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Засгийн газрын Үндэсний хороог байгуулна.
- Иргэний албанд цалин хангамжийг ажлын бүтээмжтэй уялдуулан тооцдог шинэчлэлийг нэвтрүүлэх замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Нийтэд тустай үйл ажиллагааны хууль баталж, иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтийн шинэ хувилбаруудыг бий болгоно.

- Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлнэ.
- Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, байгаль хамгаалал, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, дэд бүтэц зэрэгтэй холбоотой асуудлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжинэ.
- Судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын институт дээр төвлөрүүлж, шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулна.
- Салбарын мэргэшсэн хяналтын байгууллага бий болгоно.
- Парламентын намуудыг сонгогчдод улс төрийн боловсрол олгох, хөгжлийн бодлого боловсруулах бүтэцтэй болгоно.
- Шүүх үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, шийдвэр, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг нээлттэй болгоно.
- Шүүхийг тойргийн тогтолцоогоор шинэчлэн зохион байгуулж, прокурор, өмгөөлөл, мөрдөх албаны үйл ажиллагааг үүнд нийцүүлнэ.
- Шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгчийн бүтцийг бий болгож, хүний эрхийн баталгааг дээшлүүлнэ.
- Шүүхийн захиргааны болон шүүн таслах үйл ажиллагааг тусгаарлаж, Шүүхийн ерөнхий зөвлөлийг байнгын ажиллагаатай болгоно.
- Шүүхэд “Маршалын алба” бий болгож, эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг ялгавартай зохион байгуулна.
- Прокурорын байгууллагын хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлнэ.



- Захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эргүүлийн цагдаа, хилийн алба, татвар, бусад мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд эрсдлийн удирдлагын мөнөжмөнтийг нэвтрүүлнэ.
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг мөрдөх алба болгон нэгтгэн зохион байгуулна.
- Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар мэргэшсэн нэгж байгуулна.
- Мөрдөх албаны дэргэд шүүх шинжилгээний бүтцийг бий болгоно.
- Хэв журмын цагдааг орон нутгийн мэдэлд шилжүүлж, иргэний хяналтын механизм бүрдүүлнэ.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшил, орлогыг ил тод болгож, хэвлэлийн байгууллагуудын бие даасан байдлыг дээшлүүлж, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулна.
- Авлигатай тэмцэх асуудлыг шинэ түвшинд гаргаж авлигын индексийг эрс бууруулна.
- Хахууль өгсөн талыг авлигын хэргээс чөлөөлөх асуудлыг хуульчилна.